



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар A/97

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчит төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Дэд ахлагч:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Гишүүд:

Ц.Шинэхүү

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Одмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Э.Дуламсүрэн

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цэрэнлхам

Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн


132013742

Д.Дариймаа	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
А.Молор	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Г.Нямдаваа	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Янжинлхам	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичиг:	
Б.Амарбаясгалан	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Билгүтэ	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Төрийн өмчит төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор санал дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд танилцуулан шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
даргын 2023 оны 12 дугаар сарын 01-ны  
өдрийн 007 дугаар тушаалын хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

**Нэг: Зорилго**

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хэлэлцэн, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

**Хоёр: Хийгдэх ажлын чиглэл**

1. Төрийн өмчит төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн биелэлтийн талаар танилцах;

2 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл ажлын хэсгийн гишүүд санал дүгнэлт өгөх;

3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны үйл ажиллагааг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх авах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал дүгнэлт гаргах;

4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах арга хэмжээг зохион байгуулах.

**Гурав: Үр дүн, хугацаа**

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл, санал дүгнэлтээ 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд танилцуулан батлуулах

.....000.....